



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/97

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2, 8.4, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3, 77.7.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Татварын албанд хураагч ажиллуулах журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн болон харьяа татварын албадын дарга нарт, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Л.Нэргүй/-т даалгасугай.
3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/31 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА




Б.ЗАЯАБАЛ

ТЕГ-ын даргын..... оны дугаар сарын
&1. өдрийн 1/27 дүгээр тушаалын хавсралт



ТАТВАРЫН АЛБАНД ХУРААГЧ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.39-д заасан ажилтныг /цаашид хураагч гэх/ томилох, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, чөлөөлөх, татварын улсын байцаагчийн эрх олгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэс, сумын татварын тасагт хураагч ажиллуулж болно.

1.3.Хураагчийн албан тушаалын тодорхойлолтыг Татварын ерөнхий газрын дарга, хөдөлмөрийн гэрээ, ажил үүргийн хуваарийг харьяалах татварын албаны дарга тус тус баталж мөрдүүлнэ.

1.4.Хураагч нь ажлын үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэгтэй байх бөгөөд ажлын үнэмлэхийг харьяалах татварын албаны дарга олгож, тэмдгийг “Татварын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг хэрэглэх журам”-аар зохицуулна.

Хоёр. Хураагчийг томилох, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, чөлөөлөх

2.1.Аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэс, сумын татварын тасагт гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд сул орон тоог нөхөх зарыг Татварын ерөнхий газрын Төрийн захиргааны асуудал хариуцсан нэгж олон нийтэд мэдээлж, бүртгэнэ.

2.2. Бүртгүүлсэн иргэдээс хувийн хэргийн болон ярилцлагын шалгалт авна.

2.3.Энэ журмын 2.2-т заасан шалгалтад тэнцсэн иргэнийг Нийслэлийн татварын газар, аймаг, дүүргийн татварын хэлтэст Татварын ерөнхий газрын дарга, суманд тухайн аймгийн татварын албаны дарга тухайн сумын засаг даргатай зөвшилцөн хураагчаар нэг жилийн туршилтын хугацаатай томилно.

2.4.Дараах тохиолдолд энэ журмын 2.1 дэх заалт нэгэн адил үйлчилнэ:

2.4.1. татварын албанд татварын улсын байцаагчаар ажиллаж байгаад Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2-т заасан үндэслэлээр төрийн албанаас түр чөлөөлөгдсөн хугацаа 2-оос дээш жил өнгөрсөн тохиолдолд;

2.4.2. Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.2.1, 46.2.4, 46.2.5-д заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн тохиолдолд;

2.4.3. Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48 дугаар зүйлийн 48.1.3, 48.1.4-т зааснаар төрийн албанаас халагдсан иргэн.

2.5. Хураагч нь “Татварын албаны ажилтан, албан хаагчийн сургалтын журам”-ын 2 дугаар бүлгийн 2.1.1-д заасан сургалтад, мөн журмын 5 дугаар бүлгийн 5.5-д заасан шалгалтад хамрагдсан байна.

2.6. Хураагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах асуудлыг Татварын ерөнхий газрын даргын тушаалаар шийдвэрлэнэ.

2.7. Төрийн албаны тухай хууль, Татварын ерөнхий хууль, Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн дотоод журам болон бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг зөрчсөн аймаг, нийслэл, дүүргийн татварын албаны хураагчийг Татварын ерөнхий газрын даргын тушаалаар чөлөөлнө.

2.8. Энэ журмын 2.7-д заасан хууль тогтоомжийг зөрчсөн сумын хураагчийг тухайн аймгийн татварын албаны дарга тухайн шатны засаг даргатай зөвшилцөн чөлөөлнө.

Гурав. Хураагчид татварын улсын байцаагчийн эрх олгох

3.1. Хураагчид татварын улсын байцаагчийн эрх олгох асуудлыг “Татварын улсын байцаагчийн эрх олгох, эрхийг хасах, хүчингүй болгох” журмаар зохицуулна.

3.2. Энэ журмаар зохицуулагдаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохицуулна.

---oOo---